



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Мэдээлэл, технологийн үндэсний парк" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, 11,317,600.00 (арван нэгэн сая гурван зуун арван долоон мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 2 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2."Мэдээлэл, технологийн үндэсний парк" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Содномдамбад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001695

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 3-ны өдрийн
2018.05.03 дугаар тогтоолын хавсралт



"МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН

Д/д	Автомашини нэр, марк	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
1	Соната-5, 20-57 УБЗ (khnew41bp3a874544)	2005	385150	11,317,600.00	11,317,600.00		500,000.00
	Дүн			11,317,600.00 (арван нэгэн сая гурван зуун арван долоон мянга зургаан зуун)	11,317,600.00 (арван нэгэн сая гурван зуун арван долоон мянга зургаан зуун)		500,000.00 (таван зуун мянган)